

УВС АЙМГИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН ЭРҮҮ, ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2017.10.31

Улаангом сум

Нэг. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХИ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

Увс аймгийн цагдаагийн газарт 2017 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 600, зөрчлийн шинжтэй 1436, нийт-2036 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс -666 нэгжээр буюу -24.6 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад -198 нэгжээр буюу -24.8 хувиар буурсан байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийн 312 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж , 269 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай Прокурорын хяналтанд хүргүүлж шийдвэрлэсэн.

Захиргааны зөрчлийн шинжтэй 729 гомдол мэдээлэлд ердийн журмаар торгож, 322 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 107 гомдол мэдээллийг шүүхээр 7-30 хоногоор баривчилж, 150 гомдол мэдээллийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж торгож, 103 гомдол мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалсан байна

Архидан согтуурч захиргааны зөрчил гаргасан 741 хүнийг саатуулсан нь +80 нэгжээр өссөн байна. Нийт 7285 зөрчилд 330.555.500 төгрөгний торгууль ноогдуулсан байна. Үүнээс: Торгуулийн хуудас, бэлэн бус торгуулиар 6031 зөрчилд 184.355.500 төгрөгний торгууль, шийтгэврийн хуудсаар 1254 зөрчилд 146.200.000 төгрөгний торгууль ноогдуулсан.

Хоёр. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг: Аймгийн хэмжээнд **291** гэмт хэрэг бүртгэгдсэн, өмнөх оны мөн үеэс **+24 хэргээр буюу +8.9 хувиар өссөн байна.**

- Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 64.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -7.5 хувиар буурсан байна.

Хэрэг бүртгэлтийн хэрэг-219, мөрдөн байцаалтийн хэрэг-72

Гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

-158 хэрэг буюу 54.0 хувь нь бусад суманд

-133 хэрэг буюу 46.0 хувь нь Улаангом сумдын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн

Гарсан гаригаар нь авч үзвэл:

-Даваа-42

-Мягмар-40

-Лхагва-46

-Пүрэв-51

-Баасан-36

-Бямба-35

-Ням-41

Гэмт хэргийг гарсан цагаар нь авч үзвэл:

-06-14 цагт -62

-14-19 цагт-72

-19-22 цагт-48

-22-06 цагт-109 тус тус үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас :

Гэмт хэргийн улмаас 9 хүн нас барж, 143 хүн гэмтэж бэртсэн ба гэмт хэргийн улмаас 286 иргэн хохирсон бол 259 хүн гэмт хэрэгт холбодсон байна.

Иргэн, аж ахуй нэгж байгууллагад гэмт хэргийн улмаас нийт хохирол 444.000.000 төгрөгний хохирол учирсан ба хохиролын 285.800.000 төгрөгний хохиролыг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь нь 64.4 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад -16.2 хувиар буурсан байна. Иргэд аж ахуй нэгж байгууллагаас 281.200.000 төгрөгний эд зүйл битүүмжилж ажилласан.

Үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:

- Хүнийг санаатай алах-1
- Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг -3
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг-126
- Танхайрах гэмт хэрэг-2
- Хүчиндэх-9
- 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх-2
- Иргэдийн өмчийн хулгай-43
- Малын хулгай -46
- Тээврийн хэрэгслийн хулгай-3
- Залилан мэхлэх-2
- Завших, үрэгдүүлэх-2
- ТХХАБЖЭГХ / 215 / -14
- БХЖЭГХ-4
- Гээгдэл эд зүйл, мал ашиглах-13
- Бусдын эд хөрөнгө санаатай устгаж гэмтээх гэмт хэрэг-1
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг-1
- Бусад-20 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

Мал хулгайлах хэрэг 46 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад +21 хэргээр буюу +84.0 хувиар өссөн. Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 43 байгаа нь өмнөх оноос -12 хэргээр буюу -21.8 хувь буурсан.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 13 нэгжээр буюу 11.5 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 45 нэгжээр буюу +125.0 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргүүдийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзвэл, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг +4 нэгжээр, гэр орон сууц +23 нэгжээр, галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг +1 нэгжээр, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг +6 нэгжээр тус тус өсч бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг-5, эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн гэмт хэрэг -3 нэгжээр, хүүхэд оролцсон гэмт хэрэг -2 нэгжээр тус тус буурсан байна.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН: МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН АХМАД М.ОДХҮҮ